


2025 оны 12 сар

Савны битүүмж алдагдах нь аюултай тохиолдлын шалтгаан болдог



2014 оны 1-р сар



2021 оны 10-р сар



2023 оны 5-р сар

Нефть, химийн салбар, химийн бодистой харьцдаг, ашигладаг бүх төрлийн үйлдвэрт үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагааны аюултай тохиолдол гардаг. Аливаа бодис агуулах сав, шугам хоолойн үндсэн битүүмж алдагдах (LOPC) нь ийм төрлийн аюултай тохиолдлын нийтлэг шалтгаан болдог. Эдгээр аюултай тохиолдлын 3 жишээг өмнө нь мэдээлсэн.

Сав, шугам хоолой эврэх нь битүүмж алдагдах далд шалтгаан байдаг. Дулаалгын материалын цаагуур зэврэлт хэрхэн далд явагддаг, мөн дулаалгын материал нь зэврэлтийг түргэсгэх нөхцөл болдог тухай 2014 оны “Beacon” аюулгүй ажиллагааны мэдээллийн товхимолд мэдээлсэн. (<https://ccps.aiche.org/resources/process-safety-beacon/archives?page=3>)

Шугам хоолой, тоног төхөөрөмжийн тусгаарлалт хангалтгүй байх нь сав, шугам хоолойн үндсэн битүүмж алдагдах нийтлэг шалтгаан болдог. Тусгаарлалтын шаардлага хангаагүйн улмаас хоёр хүн амь эрсдэсэн талаар 2021 оны 10-р сарын “Beacon” аюулгүй ажиллагааны мэдээллийн товхимолд мэдээлсэн. (<https://ccps.aiche.org/resources/process-safety-beacon/archives?page=2>) Хоорондоо үл нийцэх материалыг хольсноор аюултай материал алдагдах эрсдэлтэй. Саванд буруу материал нэмж хийх нь ямар ноцтой үр дагавартай талаар 2023 оны 5-р сарын “Beacon” аюулгүй ажиллагааны мэдээллийн товхимолд мэдээлсэн. (<https://ccps.aiche.org/resources/process-safety-beacon/archives?page=2>)

Та мэдэх үү?

- Үндсэн битүүмж алдагдах гэдэг нь аливаа материал агуулсан сав, шугам хоолойн үндсэн битүүмж алдагдаж, тухайн материал гэнэт, хяналтгүй алдагдахыг хэлнэ.
- Сав, шугам хоолой их хэмжээгээр зэврэх, аюултай бодисын шугам хоолойн төгсгөлийн хаалтын хавхалгыг таглаагүй, бөглөөгүй байх нь сав, шугам хоолойн үндсэн битүүмж алдагдах эрсдэлтэйг анхааруулах дохио юм.
- Дээр дурдсан шалтгаануудаас гадна тээврийн хэрэгслээр мөргөх, механик гэмтэл учрах, чичиргээнд өртөх, сав шугам хоолойг буруу ашиглах, ажиллуулах, буруу материалаар хийх, температур эсхүл даралт өөрчлөгдөх зэрэг бусад олон шалтгаанаар сав, шугам хоолойн үндсэн битүүмж алдагдах боломжтой.
- Дулаалгын материал гэмтсэнээр ус нэвтэрч, дулаалгын материалын цаагуур зэврэлт үүсэх нөхцөл бүрдэнэ.
- Сав, шугам хоолойн үндсэн битүүмж алдагдахаас урьдчилан сэргийлэх боломжтой!

Та юу хийх ёстой вэ?

- Тойрох үзлэг хийхдээ бодис асгарсан эсэхийг шалга. Хэрэв бодис асгарсан байвал яаралтай мэдээл.
- Ямар материал асгарсныг тодорхойлж, түүнийг зогсоох хүртэл асгарсан хэсгийг тойруулан хаалт байрлуулах.
- Дулаалгын материал ховхорч унасан, бүрэн бүтэн байдал нь алдагдсан бол мэдээлэх.
- Нэг байрлалд нэг төрлийн бодис удаа дараа алдагдсан тохиолдол нь системийн тухайн хэсэгт доголдол байгааг эсхүл илүү ноцтой асуудал байж болзошгүйг илэрхийлэх тул сайтар шалгах.
- Үйлдвэрийн аюулын дүн шинжилгээ хийхдээ сав, шугам хоолойн үндсэн битүүмж алдагдсан тохиолдлын талаар мэдээлэх.

Сав, шугам хоолойн үндсэн битүүмж алдагдлаас урьдчилан сэргийл – аюултай материалыг зөв хадгал!